



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

153 /153/

2021.10.11

Үйл явдал

## ОХУ-ЫН ЦЭРГИЙН СУРГУУЛЬД СУРАЛЦАХ II ЭЭЛЖИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ҮДЛЭЭ



Өнөөдөр ОХУ-ын цэргийн академи, их, дээд сургуульд суралцах II ээлжийн бие бүрэлдэхүүнийг ҮБХИС-аас үдэн гаргах ёслолын ажиллагаа боллоо. Энэхүү арга хэмжээнд БХЯ-ны ТЗУГ-ын дарга, хурандаа С.Ванчинхүү, хэлтсийн дарга Д.Содномдаржаа, ҮБХИС-ийн сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очир нарын хүндэт зочид оролцлоо. Суралцагчдын эцэг, эхийг төлөөлж БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа Д.Ганбат бие бялдар, хүсэл зориг, оюун ухаанаараа шалгарч, эрдэм сурахаар мордож буй залуустаа амжилт хүсээд “Хүний нутагт бие биедээ түшиг болж, ядарсан нэгнээ өөд татаж, задарсан нэгнээ засаж залруулж, эрдэм номдоо шамдаж, эрүүл мэндээ хичээж, эрдмийн их далайгаас сувдыг нь шүүрч, эх орон, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өндөрт өргөж, манлайлж явахыг эцэг хүний хувьд, Зэвсэгт хүчний офицер хүний хувьд хүсэн ерөөж байна” гэлээ.

Дараа нь БХЯ-ны ТЗУГ-ын дарга, хурандаа С.Ванчинхүү суралцагчдад хандсан Батлан хамгаалахын сайдын үүрэг

даалгаврыг уламжилсан юм. Тэр бээр “Дэлхий нийтэд тархаад буй коронавируст цар тахлын улмаас та бүхний суралцах үйл ажиллагаа багагүй хугацаагаар хойшлогдсон ч Монгол Улсын Батлан хамгаалах яамнаас тодорхой арга хэмжээнүүдийг авч ажилласнаар өнөөдөр та бүхэн эрдмийн аяндаа мордож байна. Та бүхэнд бие биедээ дэмтэй байж, өөрийнхөө болон нөхдийнхөө эрүүл мэндийг сахин хамгаалж, өргөсөн тангарагтаа үнэнч, сахилга бат, сурлагаар бусдыгаа манлайлж, эх орныхоо, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өндөрт өргөж, цэргийн эрдэмд шамдан суралцахыг үүрэг болгож байна” гэв.

Ийнхүү цэргийн академи, их, дээд сургуульд суралцах II ээлжийн бие бүрэлдэхүүн ОХУ-ыг зорихоор аян замдаа мордсон юм. Монгол Улс болон ОХУ-ын Батлан хамгаалах салбарын харилцаа нь тэртээ ХХ зуунаас эхэлж, хуучнаар ЗХУ-д цэргийн мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэж ирсэн арвин түүхтэй бөгөөд 2007 оноос эхлэн ОХУ-ын цэргийн академи, их, дээд сургуульд жил бүр 50-100 орчим цэргийн алба хаагчийг суралцуулахаар илгээж, өнөөдрийн байдлаар Батлан хамгаалахын

сайдын тушаалаар Зэвсэгт хүчин, Хил хамгаалал, Төрийн цэргийн байгууллагын төлөөлөл болох 340 гаруй цэргийн алба хаагчийг ОХУ-ын 14 хотод 30 гаруй цэргийн мэргэжлээр суралцуулан бэлтгэж байна.

ОХУ-ын Воронеж хотын Нисэхийн дээд сургуулийн төгсөх курсын оюутан Б.Ганзоригийн аав, ээж хүүгээ үдэхээр хөдөө орон нутгаас ирээд байхтай таарлаа. Нисэхийн аэродромын инженер мэргэжлээр төгсөх хүүгээ зургаа дахь жилээ үдэж буй ээж “Анхны жил Төмөр замын буудлаас хүүгээ үдээд уйлаад зогсож байсныг бодвол цаг хугацаа хурдан юм аа, төгсөөд ирэх дөхсөн байна. Урьдын л адил хүүдээ “Олон түмэнтэйгээ эвтэй яваарай” гээд, эрүүл мэндээ анхаарч, дархлаагаа байнга дэмжиж явахыг хичээнгүйлэн захилаа даа” гэлээ.

ОХУ-ын Цэргийн их сургуулийн Цэрэг улс төрийн академийн сонсогч, ахмад Б.Уранбаатар эхний жил хэлний бэлтгэлдээ суралцаад ирсэн бөгөөд энэ жилээс Улс төрийн ажилтан-сэтгэл зүйч гэсэн үндсэн мэргэжлээрээ суралцахаар явж байна. Цаашид эзэмшсэн мэргэжлээрээ, ялангуяа сэтгэл

зүйчийн ажлын хүрээнд Зэвсэгт хүчинд олон талын үйл ажиллагаа зохион байгуулах нөхцөл боломж их байгааг олж харж байгаа талаараа дурдаад, илүү өргөн хүрээнд хичээнгүйлэн суралцах болно гэж эрдмийн аяны өмнөх сэтгэгдлээсээ хуваалцсан юм.

Воронеж хотын Нисэхийн дээд сургуульд Нислэгийн ашиглалтын инженерээр сурахаар анхны жилдээ явж буй дэд ахлагч Г.Бат-Эрдэнэ “Монгол Улсын Зэвсэгт хүчин жилээс жилд хөгжиж байгаа. Тиймээс би тэрхүү хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж, алсаас удирдах зэвсэг, техникийг сонирхон судалж, сайн сураад, ирээдүйд авш шигээ сайн офицер болно. Миний аав Зэвсэгт хүчний хурандаа хүн” хэмээн үе дамжсан цэргийн хүүгийн сонголтоо бахархангуй өгүүлсэн юм.

Краснодар хотын Цэргийн нисэхийн дээд сургуульд нисэхийн инженер мэргэжлээр суралцахаар мордож буй дэд ахлагч Г.Сэргэлэнбаатар “Суралцах хуваарь авснаасаа хойш цар тахлын нөхцөл байдлаас бүтэн нэг жилийг тэсэж ядан өнгөрөөлөө. Маш их баяртай байна. Ихийг сураад, эх орондоо сайн боловсон хүчин болоод ирнэ” гэв.

Түүхэнд энэ өдөр

2006 он:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 304 дүгээр зарлигаар “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” батлагдав.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 11	☁ -3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 30	☁ 22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,303,0	3,315,0
CNY	442,00	443,00
RUB	39,30	39,80
JPY	25,50	25,70
KRW	2,38	2,40

### ЗУРХАЙ

2021.10.11 ДАВАА ГАРАГ  
/БИЛГИЙН ТООЛЛЫН 6/

**НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ  
САРЫН ХӨХ ХАР ЛУУ ӨДӨР**

Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна

Наран ургах, шингэх:

07.06-18.12

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Үс

Аргын тооллын 10 сарын 11, Сумъяа гараг. Билгийн тооллын 6, Эрхтний тэнгэрт одтой, хар луу өдөр. Өдрийн наран 7 цаг 06 минутад мандан, 18 цаг 12 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахиx, хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгээ буюу засуулбал өнгө зүс сайжирна.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
319.842 +2068

ЭДГЭРСЭН  
392.453 +7722

НАС БАРСАН  
1387 +17

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
5422 +97

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
196

ЭДГЭРСЭН  
5218

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 238,630,304

Эдгэрсэн

Нийт: 215,791,079

Нас барсан

Нийт: 4,866,961

Цахим шууданд

# “ГҮЙГЧИД 032”-Т НЭГДСЭНЭЭР ...



**Зэвсэгт хүчний 032 дугаар анги**  
Монгол Улс  
“Цахим үндэстэн” болох уриалгад нэгдэж, 2021 оныг Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан ангийн Ахлагчийн зөвлөлийн санаачилгаар бие бүрэлдэхүүний бие бялдрын

бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх, идэвхтэй хөдөлгөөний энгийн дасгал болох алхалт, гүйлтээр хичээллэх, биеийн жингийн зохистой харьцааг тэнцвэржүүлэх зорилгоор “Цахим гүйлт” нэг сарын аяныг зохион байгуулж байна. Уг аянд нэгдэхийн тулд бие бүрэлдэхүүн “Strava” гүйлтийн апплейкшныг өөрийн гар утсанд суулган

“Гүйгчид 032” гэсэн клубт нэгдэж гүйлт эхэлнэ. Аянд ангийн байнгын бие бүрэлдэхүүн 100 хувь идэвх санаачилгатай хамрагдан, одоогийн байдлаар эрэгтэйчүүдээс цэргийн цагдаагийн ротын дэд ахлагч Б.Даваажав 200 км, эмэгтэйчүүдээс сувилагч Г.Амаржаргал 110 км гүйснээр хамт олноо тэргүүлж байна.

**Ахмад О.ГЭРЭЛЗАЯА**



## ЦЭРГИЙН АЛБАНААС БЭЛТГЭЛЭЭР ХАЛАГДСАН АЛБА ХААГЧДАДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

**Зэвсэгт хүчний 326 дугаар анги**

2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр тус ангиас цэргийн албанаас бэлтгэлээр

халагдсан алба хаагчдадаа хүндэтгэл үзүүлж үдэн гаргах арга хэмжээг зохион байгууллаа. Зэвсэгт хүчин, анги байгууллагадаа олон жил үр бүтээлтэй ажилласан

та бүхэндээ амьдралд нь аз жаргал, сайн сайхан, эрүүл энхийг хүсэн ерөөе.

**Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР**



## ҮБХИС-ИЙН 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН АРГА ХЭМЖЭЭ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Монгол Ундэсний батлан хамгаалахын их сургуулийн түүхт 100 жилийн ойг тохиолдуулан “Инженерийн цэргийн холбоо” ТББ, “Цэргийн инженер, химийн тэнхим” болон “Инженерийн цэргийн команд, тактикийн офицер-Зам, гүүр, барилгын машин механизмын инженер” мэргэжлийн 1996, 2001 оны төгсөгчдөөс ҮБХИС-

ийн музейн мэдээллийн сан хөмрөгт зориулан 4,3 сая төгрөгийн үнэ бүхий ухаалаг дэлгэц (COR I7)-ийг дурсамжийн хамт гардууллаа. Тус үйл ажиллагаанд ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан, сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал Ө.Эрдэнэ-Очир, БХЭШХ-ийн “Цэргийн урлаг

судлалын төв”-ийн дарга, хурандаа Б.Мөнхсайхан, “Инженерийн цэргийн холбоо” НҮТББ-ын тэргүүн, бэлтгэл дэд хурандаа Ё.Ариунболд, төгсөгчдийг төлөөлж 1996 оны төгсөгч бэлтгэл дэд хурандаа Б.Даваахүү, 2001 оны төгсөгч “Цэргийн инженер, химийн тэнхим”-ийн дарга, хурандаа Б.Мөнхбат нар оролцлоо.

## БАГАНУУР ДҮҮРГИЙН ХАМТ ОЛОН ЗОЧЛОВ

Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар болон Цэргийн штаб, хороо, багийн засаг дарга нар тус ангийн үйл ажиллагаатай танилцав.

**Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ**



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭСТЭЙ ХАМТРАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

**Зэвсэгт хүчний 284 дүгээр анги** БЗД-ийн онцгой байдлын хэлтэстэй хамтран 2021 оны 10 дугаар сарын 06-нд “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх”, “Эмнэлгийн анхан шатны тусламж” сургалтыг танхимаар болон /google

meet/ ашиглан бие бүрэлдэхүүнтэй зохион байгуулан явууллаа. Сургалтаар гамшгаас хамгаалах болон аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм, утаат орчноос аврах, галын аюулаас

урьдчилан сэргийлэх болон яс хугарах, усанд живэх, үе мултрах, амилуулах суурь тусламж, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх талаар дадлага сургалтыг үр дүнтэй зохион байгууллаа.

**Ахлах дэслэгч М.ОЧГЭРЭЛ**

